



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар A/456

Улаанбаатар хот

Г Түршилт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, 20.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын төрөлжсөн ахлах сургуулийн түршилтыг нийслэлийн ерөнхий боловсролын 32, 157, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Төв аймаг дахь Политехник коллежид 2023-2024 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлаас эхлэн тус тус зохион байгуулсугай.

2. Түршилт зохион байгуулахтай холбогдуулан доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай:

2.1. төрөлжсөн ахлах сургуулийн заавал судлах, сонгон судлах, нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүтэц бүхий түршилтын сургалтын төлөвлөгөө боловсруулах, түүнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа сургалтын хөтөлбөрийг нийцүүлэх, түршилтын арга зүй батлах, түршилтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-д;

2.2. түршилтын арга зүйд нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх болон түршилт эхлүүлэх бэлтгэл хангахыг Нийслэлийн боловсролын газар (Б.Амартувшин), Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ш.Отгон-Эрдэнэ), Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа)-т, төрөлжсөн ахлах сургуулийн түршилт зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багш нарыг давтан бэлтгэхийг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т;


2.3. түршилтыг орон нутагт хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийн явцад сар бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-тэй зөвшүүлцэн цаашид авах арга хэмжээний саналд тусгаж ажиллахыг Нийслэлийн боловсролын газар (Б.Амартувшин), Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ш.Отгон-Эрдэнэ), Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа)-т;

2.4. төрөлжсөн ахлах сургуулийн түршилт зохион байгуулахад Монгол Улсын Боловсролын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл), Нийслэлийн боловсролын газар (Б.Амартувшин), Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ш.Отгон-Эрдэнэ), Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа)-т;

2.5.төрөлжсөн ахлах сургуулийн туршилтын явц, үр дүнг Боловсрол, шинжлэх ухааны сайдын удирдлагын шуурхай хуралдаанд сар бүр танилцуулж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-д, туршилтын үр дүнд үндэслэн төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах бодлогын чиглэл, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан 2024 оны 05 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-д.

3.Тушаалын хэрэгжилтэд хагас жил тутам хяналт-шинжилгээ хийж, танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН